

1960 онд Гвиней, Куба, 1961 онд Балба, Мали, Алжир улстай тус тус дипломат харилцаа тогтоосны дээр 1960 онд Конакри (Гвиней)-д ЭСЯ-аа нээв. Ирак, Гвиней, Кубатай соёлын сабарт, БНХАУ, БНАСАУ, БНБАУ-тай шинжлэх ухаан-техникийн сабарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, БНХАУ-аас БНМАУ-д эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээрийг БНХАУ-тай тус тус байгуулав.

1960 оны эцэс гэхэд Монгол улс дэлхийн 16 улстай дипломат харилцаатай болж, хорь гаруй улстай тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтооход бэлэн байгаагаа илэрхийлжээ. Монголын дипломат алба төвдөө дал гаруй орон тоотой, сайдын аппарат, өрнөд, Дорнод, олон улсын байгууллага ба гэрээ эрх, хэвлэл мэдээлэл, ёслол, консул, санхүү, үйлчилгээ аж ахуйн гэсэн 9 хэлтэстэй, ерөнхий канцеляр гэсэн нэг газартай байжээ. Төв аппаратад нийт ажиллагсдын 87 гаруй хувь нь дээд хувь нь дээд боловсролтой ажилтнууд байлаа. Хилийн чанадад 11 улсад манай ДТГ ажиллаж байв.

1961 онд БНМАУ НҮБ-д элсэв.

Манай улс НҮБ-д элсэн орохыг хүсч, 1946 онд анх өргөдлөө өгснөөс хойш 1948, 1955, 1956, 1957, 1960 онд өргөдлөө дахин өгөх буюу мэдэгдэл хийх зэргээр уйгагүй хөөцөлдсөний дүнд 15 жилийн дараа монголын талын хүсэл биелэв.

1961 оны 12 дугаар сард Нью-Йорк хотноо БТГ-ыг нээв. Анхны байнгын төлөөлөгчөөр элчин сайд Б. Жаргалсайхан тохоон томилогдож, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга У Танд 1961 оны 12 дугаар сарын 15-нд ИЖБ-ээ гардуулан ажилдаа оржээ.

Чингэж Монгол улс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөнөөр гадаад харилцаа тэлэн өргөжих бололцоо нээгдэж, дипломат албаныхан шинэ шинэ зорилтыг хэрэгжүүлэхээр шамдан ажиллаж эхлэв.

XXI ЗУУН «ХЯТАДЫНХ « БОЛОХ УУ?

Д.Баярхүү.*

70-80-аад оноос ийм асуудал дэлхий дахины анхаарлын төвд байнга явж ирэв. Анхлан 1978 онд Хятад-Японы хооронд Найрамдлын Гэрээг мутарлаж байх үест «XXI зуун Хятад-Японы зуун болно»

*Улс төр судлаач Д.Баярхүү

гэсэн уриа түгэж байв. Сүүл рүүгээ «Японы» гэдэг үг гээгдэх нь их болж, одоо бараг нийтээрээ XXI зууныг «Хятадынх» болно гэдэгтэй эвлэрэнгүй байх бололтой. Яагаад ингэж өөрчлөгдсөнийг хэд хэдэн бодит хүчин зүйлээр тайлбарлаж болох юм. Үүнд:

1. Хятад-Японы гэж хамтатган нэрлэж байх үест Хятад нь хоёр том дайсантай 7 тэр нь СССР ба АНУг байлаа. Ялангуяа тив дээрээ Зөвлөлтийн аюул гэгчийг сөрөн зогсох үүднээс Азид холбоотон хайж байх үед Японтой харилцаагаа сайжруулсан нь Хятадын хувьд дипломатын том ялалт болов. Гэтэл 1989-1990 онд «Хүйтэн дайн» дуусч олон улсын харилцааны хоёр туйлт ертөнцийн бүтэц задарч, түүний нэг туйл болох-СССР олон улсын хуулийн субъектын хувьд ч, геополитикийн хувьд ч арчигдан алга боллоо. Одоо Хятадын хувьд Ази тивд айлгах аюул занал үгүй боллоо. Өөрөөр хэлбэл стратегийн хүчтэй өрсөлдөгч байхгүй.

2. 80-аад оны дунд үеэс «Азийн шинээр аж үйлдвэржсэн улсууд» олон улсын тавцанд илэрхий товойн гарч ирлээ. Тэд бол «дивелиопментализм» буюу хөгжлийн стратегийн загварыг амжилттай туршсан Дорнод Азийн бүлэг орон байв. Дэлхий дээр эдийн засгийн хөгжлийн гурван загвар тогтсоны (нөгөө хоёр нь либерил, коммунист) нэг нь «дорнод азийн загвар» юм. Шинээр аж үйлдвэржсэн тэдгээр орны гурав нь хятад гарлын буюу ерөөсөө «Хятадын» улс байсанд хэргийн учир оршино. Тийм орны тоо эдүгээ улам өргөжиж буй бөгөөд Тайланд, Индонез, Малайз, Филиппин гээд Хятадын соёл иргэншил хүчтэй нэвтэрсэн, хятад иргэд эдийн засгийн Гол гол өндөрлөгүүдийг нь хянадаг улсууд хэтдээ БНХАУ-ын орон зайд нэгдэх магадлалтай.

3. Дэлхий ертөнцийн хөгжлийн нийтлэг жам хууль болох интеграцийн үйл явц аяндаа Хятадын зуун гэдгийн тодотгол болно. «Хүйтэн дайн» хагас зуун жил ноёрхохдоо бүс нутгийн аливаа интеграцийг үгүйсгэх буюу хүчийг нь бууруулж, эсвэл үзэл суртал анги намын агуулга оруулж, хоёр системийн зөрчлийн хүрээнд авч үздэг байв. Тийм учраас интеграцийн хүрээ Европын хамтын нийгэмлэг, АСЕАН-аас хэтрээгүй. АНУ, Япон, Хятад, Зөвлөлт нь өөрөө бүс нутгийн хэмжээний томхон интеграцид нэгдэж орох боломж байгаагүй юм. Энд би Зөвлөлтийн дагуул-ЭЗХТЗ-ийг хэлээгүй байна. Гэтэл хоёр туйлт ертөнцийн эсрэгцэл зогсмогц Ази Номхон далайн бүс нутагт Хятадыг оролцуулсан АПЕК хэмээх томхон эдийн засгийн эвсэл ажиллаж эхэллээ. Үзэл суртал, анги намын зөрчил тэмцэлд дарагдаад хоёр орны болон гурван талын хэмжээнд явагдаж байсан далд интеграци ийнхүү ил болж дэлхийн хөгжлийг тодорхойлогч болж байна.

4. Зөвхөн эдийн засгийн хүчин зүйлээр бус улс төр-стратегийн хүчин зүйлээр Хятадын зуун болох магадлалыг авч үзэж болох байна. Юу гэвэл эдүгээ «Хэт их гүрэн», «их гүрэн» гэдэг ухагдахуунд өөрчлөлт орж шилжилт явагдаж байна. Урьд нь СССР, АНУ хоёр

тийм статусыг дархан хадгалж байлаа. Тэр хоёрыг «Хэт их гүрэн» / Хятадын гурван ертөнцийн онолоор яг тэгж нэрлэдэг ба империализм ба социал-империализм гэж ч нэрлэх явдал байсан/ гэж нэрийдэх гол шалгуур бол, 4.1: Эдийн засгийн хөгжлөөр дэлхийд хошуучилсан байх; 4.2: Цэрэг-стратегийн хувьд дэлхийд тэргүүлэх хэмжээнд байх; 4.3: Соёл-иргэншил үзэл суртлаараа дэлхийг дагуулах; 4.4: Дэлхийд хамгийн их улс төрийн нөлөөтэй байх явдал гэж үздэг байв. Өнөөдөр энэ шалгуурыг баттай илэрхийлж чадах нь мэдээж АНУ ганцаараа мөн ч хэтдээ буюу ердөө хорьхон жилийн дараа Хятад энэ хэмжээнд дөхөж очих магадлал бүрнээ нөхцөлдөж байна.

Дээр бичсэнээ олон улсын харилцааны онолын талаас тайлбарлая. Олон улсын харилцаанд ганц туйлт, хоёр туйлт, олон туйлт гэсэн бүтэц зонхилсоор, бие биеэ халсаар эдүгээг хүрсэн байдаг. Гэхдээ аливаа хэт их буюу их гүрнүүд Дэлхийн үйл хэргийг залж чиглүүлж, хувь заяаг нь тодорхойлон, дайтах, эс дайтахыг шийдэж, жижиг буурай үндэстний оршин байх, эс оршихыг тааллаараа шийдэж ирсэн гашуун үнэн буй. Тийм их гүрний тоонд Хэзээнээсээ нааш Хятад улс ордог байсан бөгөөд бүс нутгийн хөгжил дэвшил, мөхөл уналт бүгд Хятадын хүчин зүйлээс айхтар шалтгаалж иржээ. Энэ зууны эхний 40 орчим жил Британийн эзэнт гүрний цэцэглэл хөгжлийн сүүлийн төгсгөл үе шат юм. Британид аж үйлдвэрийн хувьсгал ялж, тус орон далай тэнгисийн том гүрэн болж, Испанийн хаант улсыг бөхөөснөөр олон улсын харилцаанд нэгэн бичигдээгүй хууль үйлчилсэн нь «ПАКС-БРИТАНИКА» гэж хэвшжээ. Дэлхийн хоёрдугаар дайн Британийн эзэнт гүрний мөхлийг түргэсгэж тус орон Ази, Номхон далай, Ойрхи Дорнодоос бүрэн шахагдан гарсан юм. Дайнаас хойш Британийн орыг АНУ авч, олон улсын харилцаанд «ПАКС-АМЕРИКАНА» гэсэн систем нэвтрэв. Энэ нь АНУ өөрийн мэдлийн гэж үзсэн бүс нутагтаа үндсэний эрх ашгаа баттай хангаж байх бололцоог олгожээ. Ийм нөхцөлд дөнгөж тусгаар тогтносон, сул дорой БНХАУ АНУ-ын бүс нутгийн нөлөөг эсэргүүцэх нь бүү хэл өөрөө хоёр туйлт ертөнцийн бүтцэд Зөвлөлтийн хамгаалалтанд хөдлөшгүй орсон байлаа. Өөрөөр хэлбэл Бээжин алхам бүртээ Москвагийн амыг харж байсан гэсэн үг. Ийм байдлыг зориглон эвдсэн анхны оролдлого 50-иад оны сүүлээр гарсан бөгөөд 1964-1966 онд БНХАУ нь Зөвлөлт-АНУ-ын хооронд яг ацлан тэвхдсэн байр сууринд шилжив.Цөмийн зэвсэгтэй, НҮБ-д Хууль ёсны суудлаа эзэлсэн Хятад 70-аад оны үед олон улсын харилцааны гурав дахь туйл болсон нь илэрхий боллоо.Гэвч анги намын үзэл суртал / коммунизм/ нь тэр орныг Зөвлөлтийн системээс нэг их ялгаж өгсөнгүй. Ямар ч атугай БНХАУ бол Тайванийг АНУ-аас хөндийрүүлж, америкийг өөртөө татаж, Өрнөд Европын хөгжингүй орнуудаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж, Японтой холбоотны харилцаа тогтоосноороо Ази тивээс «Пакс-Американа» системийг

шахах эхлэл тавьсан юм. 1989 онд Зөвлөлт-Хятадын харилцаа сайжирснаар /Горбачевын Бээжинд хийсэн түүхт айлчлал /АНУ Азид зөвхөн Солонгосын хойг, Японы арал дээр л ашиг сонирхлоо үлдээж бусдыг нь үндсэнд нь татан авчээ.

Товчхоноор 70-80-аад онд БНХАУ нь хоёр талын бодлогод их анхаарсан. Эргэн тойрны харилцаагаа хэвийн болгож чадсан нь тэр үеийн Хятадын түүхэн гавъяа байлаа. Гэвч 90-ээд он гэхэд энэ нь хангалттай биш болов. Өөрөөр хэлбэл Хятадын гадаад бодлогын тулах цэг- аливаа мөргөлдөөн маргаанаас зайлсхийх тэр арга явуургүй болж эхлэв. Хятадын олон улсын нэр хүнд хоёр талын хэлхээ холбоогоор цаашаа ахихаа болилоо. Олон улсын интеграцийн аливаа хэлбэрт гүнзгий оролцох нь зайлшгүй болов.

«Хүйтэн дайны» төгсгөлд америкийн ч, зөвлөлтийн ч аль ч туйл олон улсын харилцааны тодорхойлогч биш болж хувирав. Зөвлөлтийн туйл ор мөргүй устан арилж, хятадад шинэ боломж нээгдлээ. Харин Америкт олон өрсөлдөгч гарч ирэв. Жишээ нь эдийн засгийн хүч чадлын хувьд АНУ-тай Япон, ХБНГУ хоёр өрсөлдөх хэмжээнд очив. Гэтэл цэргийн хувьд, соёл иргэншлийн хувьд хаана нь ч хүрэхгүй, Оросын хувьд АНУ-тай ганцхан үзүүлэлт буюу цэрэг стратеги л үлдсэн, үлдэх үзүүлэлтийн хувьд улс төрөөр дөхөж магадгүй, бусдаар маш хол хаягдсан. Ийм нөхцөлд Хятад нь гадаад хэлхээ холбоогоо идэвхжүүлж, энэ дөрвөн үзүүлэлтээр аль алиныг тэгшхэн хангаж аажмаар ахиулах ёстой. Үүндээ ч зарим талаар хүрлээ.»Хүйтэн дайны» дараахи ертөнцийг хоёр туйлаас олон туйл-руу шилжих зурвас үе гэж нэрлэх болов. Үүнийг олон улсын харилцааны үг хэллэгт «ПАКС-КОНСОРЦИУМ» гэж томъёолж байна.

«Пакс-Консорциум» системийн гол онцлог бол:

1.Хамтын хүч чармайлтаар дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаална. Үүний жишээ Персийн буланд Иракийн эсрэг дайн хийснээр харагдсан. Түүхэндээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүд анх удаа тийм нэгдмэл байр суурь баримталсан хэрэг, Пакс-Консорциумын зарчмаар бол эдгээр таван гишүүн дээр ХБНГУ, Японыг оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа. Энэтхэг, Бразил хоёр нэмэгдэх магадлал улам өсч байна.

2.Эдийн засгийн салбарт дэлхийн шинэ дэг журам төлөвшиж байна. Урьд нь хоёр системийн уралдаан мэтээр үзэж ирсэн бол одоо бүс нутгуудын хоорондын шударга өрсөлдөөн гэж үзэх болж байна. Одоо дэлхийн хэмжээнд эдийн засгийн гурван том төв бүрдээд байна. Тэр нь:Европын Холбоо; Умард Америк; Номхон далайн баруун хэсэг буюу бидний нэрлэдэгээр Зүүн Ази юм.

3.Улс үндэстнээс дээгүүрх бүтэц улам бүр бодитой болж байна. Хэрэв Европын хамтын нийгэмлэг «Хүйтэн дайныхаа» дарамтаас салаагүй бол хэзээ ч Европын холбоо болохгүй байсан.

АСЕАН хүрээгээ тэлж, анги намын эрх ашиг гэлтгүй Вьетнамыг элсүүлэв. Европын Холбоо-АСЕАН-ны хамтарсан дээд хэмжээний уулзалт болов. Ази-Европыг дамнасан нэгэн том бүтэц үндсээ тавилаа. Дээр нь АПЕК нэмэгдэнэ. Үндэсний төр улсуудын явцуу эрх ашиг улам бүр хумигдана.

4.Энэ бүхнээс үүдэн бие даасан улсуудын бие даасан чанар хязгаарлагдмал болох тийшээ хандав. Тухайн улс орны эрх ашгаас илүү үндэс дамнасан корпорац, банк санхүүгийн бүлгийнхний эрх ашиг илүүтэй болж буй хэрэг. Үүнийг улс үндэстнээс гадуурх загвар гэж үздэг.

Хоёр системийн зөрчил тэмцэл алга болсноор нийгмийн байгууллын төлөө / социализм, эсвэл капитализм/ ангийн ширүүн тэмцэл түүх боллоо. Гэхдээ үүнийг өөр хэлбэрийн тэмцэл өвлөн авлаа. Тэр нь соёл иргэншлүүдийн хоорондын тэмцэл юм. Өнөөдөр Дэлхийд шашны дайнд босох чадалтай шашин бол лал буюу ислам юм. Гэвч күнз, христосын соёл иргэншил түүний өмнө хүчгүй болсон хэрэг биш. Дэлхийд үлдэх гуравхан шашин, түүнийг дагасан соёл иргэншлийн тухай ярьж байна. Бусад нь бүгд устахгүй ч хүч нөлөө нь нийгмийн хөгжлөө дагаад суларна гэж үзэж болох юм. Тэр их тэмцлийн талбар нь бидний оршин буй Ази тив болно. Үзэл суртлын тэмцлийн эрч далайц суларсан нь огт төсөөлөөгүй байсан нутгаас өнөөдөр фанатик маягийн улайрсан үзэл суртал дэгдэх хөрсийг бий болгов. Жишээ нь лалын фундаментализм, арабын универсализм. Энэ хоёр суртал Умард Африкаас эхлэн Баруун өмнөд Ази хүртэл өргөн уудам бүс нутагт хүрээгээ тэлж, улмаар ТУХН-ийн хил даваад байна. Зүүн тийш явсаар Азид Хиндусын болон Күнзийн соёл иргэншилтэй халз тулгарах бөгөөд нийгэм-эдийн засаг, соёл иргэншлийн томхон өрсөлдөөнд хүргэнэ гэж улс төрчид урьдчилан таамаглаж байгаатай санал нэг байна. Энэ тэмцлийг уг үзэл суртал өөрөө үнэн зөв, итгүүлж үнэмшүүлэх увдистай гэхээсээ эдийн засгийн хүчин зүйл нь илүү шийдэж өгөх байх.

Энэ дэвсгэр дээр авч яривал 2000 жилийн түүхтэй Хятадын соёл иргэншил /зөвхөн шашнаар яриагүй байна тэсч үлдэх төдийгүй эргэж довтлох магадлалтай. Азид Европын тэргүүний юм бүхэн нэвтрэх боловч улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, соёлын зарим уламжлал тэгтлээ шаардлагатай биш байна. Азид Европ, Америкийн хүчийг саармагжуулагч гол хүчин зүйл бол нөгөөх 2000 жилийн түүхтэй соёл иргэншлийн суртал мөн. «Хятад бол Дэлхийн болон Азийн соёлын ууган төв» гэсэн төвч үзэл Хятадаас гадна Япон, Солонгост хүчтэй түгсэн юм. Өнөөгийн БНХАУ, Азийн бар улсууд Тайвань, Сингапур, Гонконг, цаашлаад Макао, мөн Тайланд, Малайз, Индонез гэх мэт Зүүн Өмнөд Азийн орнуудыг

бүхэлд нь / тропикийн буюу халуун бүсийн Ази/ «Хятадын соёлын нөлөөнд буй» гэж үздэг нь тэдний хооронд анги нам, үзэл суртлын ялгаа бараг байхгүйтэй адил юм. Аж төрөх хэвшил, хөдөлмөрийн дадал зуршил, уламжлал, философи гэх мэт олон хүчин зүйл энд тал талаасаа уулзалдаж холбогдож буйг анхаарах хэрэгтэй.

Ухаандаа энэ их хүч, энэ их орон зай XXI зуун гараад өөр хоорондоо нийлэх тавилантай гэж хэлэх гээд байна. Өнөөдөр БНХАУ-д оршин буй коммунист намын засаглал бол ердөө өнгөн төдий засал. Хятадын уламжлалт фанатизмын нэг хэлбэр. Түүнээс бус СССР-т оршиж байсан ленинч-сталинч дэглэмээс үндсээрээ ялгаатай. Марксизм хэзээ ч хятадын нийгмийн толь байгаагүй, засварласан, үндэсний агуулгатай, күнзийн суртлаас эхтэй тийм л бүрхэг коммунизмын тухай хятадууд төсөөлсөөр ирсэн. Тийм учраас өнөөгийн ХКН-ын засаглал бол XXI зууны их интеграцийг саатуулагч биш харин ч хөхүүлэн дэвэргэгч болно.

Хятад хаашаа явж байна вэ? Юу руу тэмүүлж байна вэ? БНХАУ үнэндээ коммунизмын гэрэлт ирээдүйд хүрэх үү? ХКН-ын хамгийн сүүлийн их хурлын илтгэлээс үзэхэд ирэх 100 жил бол социализмын эхний шат мөн гэж заасан нь тус орныг хэтдээ Коммунизмын гэрэлт ирээдүй хүлээж буйн үндэслэл болж чадахгүй. Энэ бол онолын түр зуурын төөрөгдөл, ердөө СССР задран унасны дараахи үзэл суртлын орон зайг бөглөх гэсэн оролдлого гэж би үздэг. Хэрэв Зян Зэманий тэрхүү илтгэлийн заалтад итгэх юм бол үндэсний онцлог, нөгөө күнзийн соёл иргэншил, улсын дээгүүрх бүс нутгийн бүтэц зэрэг дээр хөндсөн зүйлүүд яах болж байна.

Хятад бол үнэндээ коммунизмын замаар явж буй биш юм. Эдийн засгийн талаас нь авч үзвэл Хятад шиг либерал, нээлттэй реформ хийж буй айл байхгүй, тэр утгаараа гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн чадварлаг татаж буй улс юм. Хятадын өнөөгийн реформ нь дайны дараахи Японы хөгжлийн стратегийн загвараас онцын ялгарах юмгүй. Тэр загвараар тухайн цагтаа Зян Зингогийн Тайвань, Пак Жөн Хийн Өмнөд Солонгос, Ли Куан Ю-гийн Сингапур замнасан бол эдүгээ Дэн Сяопиний Хятад замнаж буй. Тэр загварын онцлог нь хожмынхоо ардчиллыг нэлээд эртнээс ултай суурьтай бүрдүүлдэг явдал. Тэр жамаараа Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур, Филиппин, Тайландад ардчиллын институт их хожуу төлөвшсөн юм.

Тийм учраас Хятадад хэтдээ нэг намын хатуу засаглалаас олон намын систем, ардчилал руу цус урсгахгүй аажуу шилжих хөрс бүрдэж байна. Коммунизмын тоталитари бүтцийг Хятадад «Соёлын хувьсгалаас» эхлэн эвдсээр 1978 оны Намын Төв Хорооны түүхт гуравдугаар бүгд хурал хүрэхэд ямар ч эсэргүүцэлгүй болгочихсон байсан юм. Тэгээд нийгэмчилсэн эдийн засгийн том бүтцийг эвдэж,

өмчийн олон хэлбэр рүү орж, хувийн санаачилгыг хөхүүлж, хожуухан түүнээ хуульчилсан хэрэг. 80-аад оны сүүл гэхэд Хятадыг «Улаан туг дор капитализм байгуулж буй улс» гэж хошигнож байсан нь үнэний ортой.

Коммунист намын засаглалын хатуу бүтцийг нураах явц Хятадад цаашид явагдана. Яагаад гэвэл анги намын үзэл суртал гол биш боллоо. Манай эрин үеийн зөрчлийн мөн чанар өөрчлөгдлөө. Тэгээд ч дэлхийн хөгжлийн хувь заяаг шийддэг «7-гийн бүлгийн үйл ажиллагаанд БНХАУ хүссэн хүсээгүй оролцож эхэлж байна. АПЕК ийн гишүүд дотор Хятадтай зэрэгцээд АНУ, Япон, Канад гурав байгааг энд Жишээлж болно.»7+1» хувилбараар ОХУ »7-гийн бүлгийн» үйл ажиллагаанд уригдаж байгаа. Энэ бүлгийн түүхийг эхэлсэн цагаас нь долоон жилээр ангилдаг бөгөөд одоо дөрөв дэх долоон жилдээ ороод байна. 1996 оноос эхлэх энэ долоон жил дотор багтаж БНХАУ энэ том эвслийн хаалгыг татна гэсэн таамаглал газар сайгүй дэвшүүлж байна. Хэрэв «7+2» буюу «9-ийн бүлэг» үүсвэл тэд дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг дангаараа гаргах болно (Одоо «7-гийн бүлэгт» энэ үзүүлэлт 64 хувьтай байна)

Одоо БНХАУ-ын хөгжлийн хурдац, эдийн засгийн үзүүлэлтүүдийг бусад бүс нутаг, улс орнуудтай харьцуулаад эрдэмтэд, улс төрчид доорхи тооцоо хийж байна. 2010 он гэхэд БНХАУ хөгжлийн үзүүлэлтээр Япон, Өрнөд Европыг гүйцэж, ардаа орхих ба 2020 он гэхэд бүх үзүүлэлтээр АНУ-тай зуузай холбоно. Өөрөөр хэлбэл олон улсын харилцаа дахин хоёр туйлт ертөнц рүү шилжих үү, эсвэл тэгш эрхтэй олон туйлууд үргэлжлэн зэрэгцэн орших уу? гэдгийн шийдэл болж өгөх аж. Хэрэв Хятадын хөгжлийг боймлох гээд элдэв хориг тавих, дотроос нь хагалах, хуваах оролдлого хийвэл ганцхан Хятад хохирохгүй. Дор хаяж 10 сая дүрвэгч хил давах бөгөөд түүний давалгаанд юуны өмнө Зүүн Азийн арал, хойгийн орнууд бүгд нэрвэгдэнэ. Энэ бол японы судлаачдын хийж буй тооцоо. Тийм учраас Хятадад үргэлжлэн хөрөнгө оруулалт хийж, түүний тогтвортой байдлыг дээд зэргээр хангахыг дэлхийн том гүрнүүд бүгд хүсч байгаа. Хятад ч өөрөө зүгээр алмайран суугчийн дүр эсгэхгүй. Үйлдвэрлэл, хангалт нийлүүлэлтийн их шилжилт явагдаж, XXI зуун орвонгоороо өөрчлөгдөнө гэж үзэж байна. Умард Америк, Европ, Япон үйлдвэрлэлийн олон салбараа хаах буюу зориулалтыг нь өөрчлөнө. Ерөөсөө дагнах шаардлагагүй хэрэглээний олон салбар хаагдана. Яагаад гэвэл гол үйлдвэрлэгч нь Хятад болох юм. Түүний эхлэл ч хэдийнэ тавигдсан. АНУ, Япон, Европын зах зээлд гэрийн хувцас, хүүхдийн тоглоом, хүүхдийн хувцас, хуванцар эдлэл Хятадынх голлож байна. Энэ нь хүрээгээ тэлж, өөр нэрийн бараагаар нэмэгдэнэ. АНУ хамгийн том хэрэглэгч хэвээр үлдэх боловч Европ, Япон түүнээс нэг их хоцрохгүй. Хятад болон Зүүн Азийн орнууд дэлхийг өргөн хэрэглээний бараагаар бүрэн хангах төдийгүй автомашин, хөлөг онгоц, компьютер, хагас дамжуулагчийн

салбарт ч зонхилох магадлалтай. Европчуудын хэрэглээ багасахгүй нь мэдээж, гэвч Европ бол нийлбэр утгаараа «Дэлхийн хамгийн том музей» болох юм.

Энэ их зорилтыг хэрэгжүүлэхийн тулд БНХАУ дангаараа хүчин зүтгэхгүй нь дээр тодорхой байна. Гэхдээ Тайванийг зэвсгийн хүчээр чөлөөлөх мэтийн адал балмад санаархлаасаа эргэлтгүй татгалзаж, тэр арлын статус-квог бүрэн хүлээн зөвшөөрснөөр валют санхүүгийн асар их боломжтой болно. Гонконг, Макаог удахгүй нэгтгэх боловч тэнд дарангуйлал хэрэгжүүлэх бүх хувилбараас бас татгалзах ёстой. Тайваньтай эдийн засгийн гүнзгий интеграцид орж, бүсийн хэмжээний эдийн засгийн томхон бүтэц /АНУ, Канад, Австралийг үл оролцуулан бий болговол тэртээ тэргүй XXI зуун аяндаа Хятадынх болно гэж гадны судлаачид үздэг юм билээ.

Холбогдох ном хэвлэл

- 1.О.Нямдаваа. XXI зуун ба Ази, Номхон далайн орнууд, «Дорно-Өрнө» сэтгүүл, 1994 № 1(34)
- 2.Д.Баярхүү.Олон улсын харилцааны систем ба Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал, «Засгийн газрын мэдээ» 1996.09.05 № 170 (610)
- 3.Өмнөд хөршөөр, «Стратеги судлал» сэтгүүлийн тусгай дугаар 1995 №2
- 4.Я.Накасонэ, Я.Мураками, С.Сато, С.Нисибэ.После «Холодной войне» (Совместное исследование) Москва, «Прогресс», «Универс», 1993
- 5.Dan Gallin. Inside the New World Order: Drawing the Battle Lines, New Politics, Vol.V, №1, Summer 1994
6. Richard Baum. Political Stability in Post-Deng Cnina, Asian survey, Vol, XXXII, №6 June 1992

АЗИЙН ЧИГЛЭЛИЙН УРТ ЗАМД

Д.Эрдэмбилэг*

XXI зуун бол Азийн эрин зуун болно гэж үздэг. Энэ зөн билэг. Азийн зүрхэнд орших нутаг уудам, хүн ам цөөн, хөгжил буурай, далайд гарцгүй, эх газрын дөрвөн улирлын эрс тэс уур амьсгалтай Монгол орны хувьд ээл ивээлтэй байх болтугай.

Төв Азийн Алтай, Саян, Хэнтий Хангайн уул нуруудын үр шимт хөндий, дорнодын тэгш тал, өмнөдийн их говиор нүүдэллэн

* Элчин сайд ахмад дипломатч.